



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2023 оны 05 дугаар сарын 16

Дугаар 09/01

Баян-Өндөр сум

**Хуралдааны дэг батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус IX хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус IX хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай.
2. Хуралдааны дэгийг мөрдөж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хуралдаанд оролцогчдод үүрэг болгосугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн Ээлжит бус IX хуралдааны 09/01 дүгээр тогтоолын хавсралт

## АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ БУС IX ХУРАЛДААНЫ ДЭГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит бус IX хуралдаан 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 09:00 цагт аймгийн Нутгийн удирдлагын ордны А.Амарын нэрэмжит их танхимд эхэлнэ.

Хурлын дарга, аймгийн Засаг дарга, Ажлын алба, иргэний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид, Авто тээврийн төвийн дарга нар танхимаар оролцоно.

Төлөөлөгчид zoom программ ашиглах шаардлага хангасан техник хэрэгслийн бэлэн байдлыг өөрөө хангаж, байгаа байршлаасаа оролцоно.

1.Иргэний зөвлөлийн зарим гишүүнийг чөлөөлж, томилох тухай 10 минут  
2.Бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 5 минут  
3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус IX хуралдаан цахимаар зохион байгуулагдаж байгаатай холбоотойгоор хэлэлцэж байгаа асуудлаар гарах шийдвэрийн төслийг эцэслэн боловсруулах Редакцын комисс, санал хураалтын үйл ажиллагааг зохион байгуулах, дүнг гаргах тооллогын комиссын үүргийг Хурлын Ажлын албанаас эрхлэн зохион байгуулна.

4.Хуралдаанд оролцож байгаа Төлөөлөгчдийн ирцийг zoom программд холбогдсоноор хуралдаанд оролцсонд тооцох ба mlsp.mn программаар бүртгэнэ.

5.Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар Хурлын төлөөлөгч зориудаар хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно. Хуралдаанд зориудаар оролцоогүй буюу орхиж гарсан тохиолдолд хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.

6.Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар Төлөөлөгчдийн асуулт асуух хугацаа 3 хүртэл минут, санал хэлэх хугацаа 2 хүртэл минут байна.

7.Тухайн асуудлаар асуулт асуух, санал хэлэх Төлөөлөгчдийн нэрсийг хуралдааны удирдлагын зүгээс mlsp.mn программаар урьдчилан авч дараалалд оруулна. Төлөөлөгчид тус программын санал гэсэн цэс дээр даран өөрийн нэрээ урьдчилан өгнө.

8.Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар эцсийн шийдвэр гаргах, асуулт, хариулт, санал, шүүмжлэлийг таслахдаа санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.

9.Хэлэлцэж байгаа асуудлаар цөөнх болсон Төлөөлөгчдийн үндэслэл, саналыг сонсож, дахин нэг удаа санал хураалт явуулж болно.

10.Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Намын бүлэг завсарлага авч болох бөгөөд завсарлагын хугацаа 1 цаг хүртэл байна. Бүлгээс тухайн асуудалд нэгдсэн байр суурь илэрхийлж хуралдаанд оролцоно.

11.Намын бүлэгт олгосон завсарлагын хугацаа сунгах шаардлага гарвал хуралдаанаар шийдвэрлэх бөгөөд тогтоосон хугацааг чанд баримтална.

12.Асуулт тавих, үг хэлэх, санал шүүмжлэл гаргах зөвшөөрлийг хуралдааны удирдлага олгож тогтоосон хугацааг баримтална.

13.Хуралдааныг 2 цаг тутам 15 минутын завсарлагаатай явуулна.

14.Өдрийн их завсарлагыг 13.00-14.00 цагийн хооронд байна.

15.Хуралдаан тухайн ажлын өдөр багтахгүй бол үргэлжлүүлэх аль эсвэл дараачийн өдөр шилжүүлэх асуудлыг санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.

16.Хуралдааныг орон нутгийн телевиз, сайт зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэдэд мэдээлэл дамжуулах боломжийг хангана.

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ЭЭЛЖИТ БУС IX ХУРАЛДААН**